



*Хууль сахиулахын их
сургуулийн Удирдлагын
сургуулийн сонсогч, хониууч
Ц.Алтантулга*

ХОРИХ АНГИАС ОРГОСОН ЯЛТНЫГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Монгол Улсын улс төр, эдийн засаг, хүн амын эрүүл мэндэд ил, далдаар гадаад орчноос аюул нүүрлэж байгаа өнөө үед дотооддоо эрүүгийн нөхцөл байдал хүндэрсэн, онц ноцтой гэмт хэргийн гаралтын тоо ихсэх болсон, цаазаар авах ялаас татгалзсан, шүүхээ соногдуулах ял шийтгэлийн бодлогод өөрчлөлт орсон зэрэг шалтгаан нөхцлийн улмаас ялтны тоо нэмэгдэж хорих ангийн хяналт, харуул хамгаалалтын нөхцөл байдал хүндэрч цаашлаад нийгэм, иргэдэд учирч болзошгүй аюул занал оршсоор байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлд “Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргосон, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 261.2 дахь хэсэгт “Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, эсхүл харуул манаанд зэвсэг, хүч хэрэглэж буюу хорих ангийн барилга байгууламж, хамгаалалтын тоног төхөөрөмжийг эвдэж оргосон бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 262 дугаар зүйлд “Түр чөлөөгөөр явсан ялтан тогтоосон хугацаанд

хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хорих ангидаа буцаж ирэлгүй ял эдлэхээс зайлсхийсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан.

Улс, орны нийгэм, эдийн засгийн уналт, доройтол, хуулийн байгууллагын боловсон хүчний хангалт, нөөц алдагдсан үеийн 1990-2000 оны хугацаанд хорих ангиас ялтан оргох, бүлэглэн оргох, зүй бус нас баралт нэмэгдсэн уналтын хүнд жилүүд байлаа.

1996 оны 01 дүгээр сарын 04-ний шөнө Ч.Чулуунбаатар нарын 3 ялтан Авдрантын гяндангаас зэвсэглэн 5 хүний амийг хороон, бусдыг барьцаалан оргосон хэрэг гарснаар төр, засаг Хорих байгууллагын боловсон хүчин, харуул хамгаалалт, аюулгүй байдалд онцгой анхаарах болсон нь Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Хорих байгууллагуудад нийт бие бүрэлдэхүүний сахилга, харуул хамгаалалтын ажлыг сайжруулах тухай” 23 дугаар тогтоолоос харж болно.

Сүүлийн жилүүдэд ялтнууд оргох гэмт хэргийг нарийн тооцоотой, урьдчилан төлөвлөж, бүлэглэн, зохион байгуулалттайгаар үйлдэх болсон нь 2011 оны 07 дугаар сарын 31-ний өдөр насанд хүрээгүйчүүдийн Хорих 411 дүгээр ангиас 6 ялтан бүлэглэн, 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Мааньтын хорих ангиас 3 ялтан бүлэглэн, 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Дарьтын хорих ангиас 2 ялтан бүлэглэн оргосноор харагдаж байна.

2000 оноос хойш хорих ангиас ялтан оргох гэмт хэргийн гаралт 2010 он хүртэл багасч, 2010 оноос өнөөг хүртэлх хургацаанд ялтан оргох гэмт хэрэг нэмэгдэж байгаа нь Тогтоол гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн тасгийн судалгааны материалаас харагдаж айна.



Хорих анги, ЦХБ-наас оргосон	ялтнысудалгаа											
Орголт	2002 он	2003 он	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	
Тухайн онд хорих анги болон ЦХБ – наас нийт оргосон	73	68	49	40	35	18	10	14	10	12	15	
Тухайн онд оргосноос барьсан	68	56	26	30	31	16	10	14	10	12	15	

Тогтоол гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн тасгийн судалгаа/

Ялтан оргохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нь хорих байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго бөгөөд эрх зүйн хувьд тодорхой тусгалаа олсон байдаг.

Тогтоол гүйцэтгэх газрын чиг үүргүүдийн чухал нэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь хэсэгт зааснаар “ялтны аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх” явдал юм. Мөн Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9.1.4 дэх хэсэгт “шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах”, 11.4 дэх хэсэгт “Хорих ял эдлүүлэх байгууллага энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хоригдлын дунд, түүнчлэн оргосон ялтныг баривчлах зорилгоор эрэн сурвалжлах ажил явуулна”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх тагнуулын ажлын зааварт “Ялтны дунд ноцтой зөрчил, оргох болон бусад гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор, мөн оргосон ялтныг эрэн сурвалжлахад гүйцэтгэх

ажил явуулах”, мөн түүнчлэн Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журмын 2.11-д “Хорих ангид бий болсон дараахь нөхцөл байдлыг онцгой учралд тооцно. 2.11.1. Бусдын амь насыг санаатайгаар бүлэглэж буюу онц хэрцгийгээр хөнөөх, албан хаагчийн амь бие, эрх чөлөөнд хүч хэрэглэн халдах, хориотой бүсийн байгууламж, тоног төхөөрөмжийг эвдэн сүйтгэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болгох, ялтан бусдыг барьцаан давах, бүлэглэн буюу зэвсэглэн оргох, хорих ангийн харуул хамгаалалтанд халдах” гэж заасан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ялтан оргохоос урьдчилан сэргийлэхэд онцгой анхааран хорих ангийн харуул хамгаалалтын бүсийг хуульд заасан шаардлагын хэмжээнд хүргэх, ялтны ухамсар, сэтгэлгээнд нь нөлөөлөн гэмт санаа бодлоос нь татгалзуулах бодлого барин ажиллаж байна.

ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Монголын хууль цаазын нэр томъёонд “Эрэн сурвалжлалт” гэдэг үг түүхэн сурвалжтай бөгөөд түүний агуулга нь эхлээд их өргөн, олон утгатай байжээ. Чингэс хааны “Ихзасаг” нэгдмэл хуулиас эхлэн 1640 оны “Монгол-Ойрадын хууль”, 1709-1795 оны “Халхжуралт” хуулиудад “Эрэн



сурвалжлалт” гэдгийг “цэрэг аян дайн хийж байхад оргож зугатагсад, байлдааны талбараас зугтаагсад, цэргийн албанаас зайлсхийх зэргийг гэмт хэргийн эзэн гэж заан, тэднийг олж, ял оноох”-оор зааж байсан жишээтэй байна.

Ялтан оргосон үеийн эрэн сурвалжлах ажиллагааг хорих анги, албаны “Шуурхай бүлэг”-ийн ажилтнууд, Тогтоол гүйцэтгэх газрын “шуурхай бүлэг”, бусад хорих анги, албаны хүч, Эрүүгийн цагдаагийн газрын 6 дугаар хэлтэс, харъяалах цагдаагийн байгууллагын хүчээр зохион явуулах ба нутаг дэвсгэрийн хил хязгаараас шалтгаалан орон нутгийн, бүсчилсэн, улсын хэмжээний, олон улсын гэсэн 4 хэлбэрээр явуулна.

1. Орон нутгийн эрэн сурвалжлах ажиллагаа гэдэг нь цагдаагийн газар, хэлтсийн тодорхой нутаг дэвсгэрт бие даан зохион байгуулж байгаа ажиллагааг хэлнэ.

2. Бүсчилсэн эрэн сурвалжлалт гэж оргосон этгээдийг эрэн сурвалжлан баривчлахад тухайн орон нутгийн хэд хэдэн хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн газар, хэлтсийн хүчээр зохион байгуулах ажиллагааг хэлнэ.

3. Улсын хэмжээний эрэн сурвалжлалт гэж орон нутгийн болон бүсчилсэн эрэн сурвалжлах ажлын явцад зохион байгуулсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд бүх хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагааг татан оролцуулан зохион байгуулж байгаа ажиллагааг хэлнэ.

4. Олон улсын эрэн сурвалжлалт гэдэг нь тус улсын хилийн гадна байгаа эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийг гадаад орны цагдаагийн байгууллагын оролцоо, тусламжтайгаар олж тогтоохоор Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх

Интерполын Үндэсний Төв товчоогоор зуучлуулан зохиох ажиллагааг хэлнэ.

Эрэн сурвалжлах ажиллагааны явцад дараахь тулгамдсан асуудлууд байна.

1. Нийгмийн хөгжлийг даган ялтнууд гар утас хууль бусаар эзэмших явдал ихэссэн ба оргож явах хугацаандаа эрэн сурвалжлах ажиллагааны явцын тухай мэдээллийг ойр тойрныхоо хүмүүсээсээ аван хаяг байршлаа өөрчлөн эрлийн ажиллагааг удаашруулдаг. Тухайн оргодлын ашиглаж буй гар утасны дугаар, ярианы тухай лавлагаа, хаяг байршлийг тогтоох талаар холбогдох үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандахад татгалздаг. Энэ асуудал манай байгууллагын үйл ажиллагаанд ч биш Цагдаагийн байгууллагад тулгамдаж буй асуудал ба Дархан-Уул аймагт хүүхэд хулгайлан, мөнгө шаардсан гэмт хэрэг гарахад тулгарч байсан.

2. Оргосон ялтны харъяалах орон нутгийн захиргаа болон бүртгэлийн байгууллагаас шаардлагатай лавлагаа, мэдээлэл авахад албан ёсны бичиг, тоотуур хандахыг шаарддаг нь эрэн сурвалжлах ажиллагааг удаашруулдаг ба албан тушаалын үнэмлэх бичиг баримт ямар ч холбогдолгүй болдог. Эрэн сурвалжлах ажиллагаанд халхавчийн бичиг баримт ашиглах нь тодорхой мэдээллийг олох, орон байранд нэвтрэх, үзлэг, нэгжлэг явуулах, тээврийн хэрэгслийг шалгах, шаардлагатай газруудад саадгүй нэвтрэн орох зэрэг ажиллагаанд нааштай үр дүн үзүүлдэг.

3. Монгол хүний гүйж яваа морь, ядарч яваа эр хүн хоёрт саад болохгүй гэсэн сэтгэлгээнээс болж ард, иргэд оргодлын талаар үнэн зөв мэдээлэл өгдөггүйгээс эрлийн ажиллагааг өөр чиглэлд явуулах зэрэг хүндрэл учруулдаг.



4. Практикт бүлэглэн оргосон тохиолдолд л улсын хэмжээний эрэн сурвалжлалт явуулах хандлага байдаг ба ганцаараа оргосон ялтныг Хорих байгууллага өөрийн хүч хэрэгслээрээ эрэн сурвалжлах ажиллагааг явуулдаг нь учир дутагдалтай ба хүний тооноос хамааралгүй аюулгүй ялтан байдаггүйг санаж олон нийтэд нэн даруй зарлаж мэдээлэх нь зүйтэй.

5. Тээврийн хэрэгслийг өмчийн хэлбэр харгалзахгүй дайчлах хуулийн заалттай боловч энэ асуудлыг зохицуулсан журам, зааваргүйн улмаас төлбөр тооцоо, гарах хариуцлага, үр дагавраас нь болж хэрэгжүүлдэггүй.

6. Оргодлууд нь ял эдлэх явцдаа тухайн хорих ангийнхаа албаны болон албан хаагчдын тээврийн хэрэгслийн марк, загвар, улсын дугаар зэргийг мэддэг, нарийн сайн судалсан байдаг ба эрэн сурвалжлах ажиллагаанд дээрхи тээврийн хэрэгсэл ашиглах нь үр дүнг багасгадаг. Практикт зарим хорих ангийн гүйцэтгэх тагнуулын албанд тээврийн хэрэгслийн улсын дугаарыг халхавчийн хэлбэрээр ашигладаг ба үр дүнтэй байдаг

Тайван цагт хөлс их урсгавал дайны цагт цус бага урсана гэсэн үг байдаг. Хорих байгууллагын ажилтан бүр энэ үгийг байнга санан ялтан оргохоос урьдчилан сэргийлэхэд бүх хүч, нөөц, боломжоо чиглүүлэн ажиллах нь зүйтэй юм.

Маршалын албаны тухай хуулийн төсөлд Маршалын алба нь шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэгтэй байх заалт байгаа. Эрэн сурвалжлах ажиллагаанд тулгамдаж буй эдгээр асуудлууд нь Маршалын албанд тулгарч болзошгүй юм.

1. Ялтны мэдээллийн цахим санг байгуулах, мэдээллийн солилцоог сайжруулах

2. Иргэний бүртгэлийн байгууллагын цахим сантай холбогдох, ялтны ар гэрийн мэдээлэл /хаяг, гэр бүлийн, утас, иргэний бичиг баримтын, хөрөнгийн, найз нөхдийн гэх мэт/-ийг шуурхай авч байх.

3. Үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгч компаниудаас холбогдох мэдээллийг шуурхай, олон шат дамжлагагүй авах нөхцлийг бүрдүүлэх

4. Эрэн сурвалжлах, мөрдөн хөөх ажиллагааны заавар, журмыг шинэчлэх

5. Нийслэл, орон нутгийн нутгийн захиргаа, хуулийн байгууллагаар дамжуулан иргэдээс оргодлыг нуун дарагдуулдаг, үл мэдээлдэг сэтгэлгээ, хандлагыг өөрчлөх

6. Хорих ангийн хамгаалалтын бүсийн стандартыг тогтоох, хуульд заасан хамгаалалтын бүсийг шаардлагын хэмжээнд байгуулах

7. Ялтныг эргэж ирэгсдийн гэрэл зургийг авч байх.

8. Эрэн сурвалжлах ажиллагааны тээврийн хэрэгсэл, унааны хангалтыг сайжруулах, нөөцийг тасралтгүй байлгах, халхавчийн бичиг баримт, автомашин, автомашины улсундугаар олголтын асуудлыг шийдвэрлэх,

ДЭВШҮҮЛЖ БҮЙ САНАЛ